



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 12 сарын 14 өдөр

Дугаар 6/60

Хэрлэн сум

Д.Баярхүүг ажлаас чөлөөлөх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.21, Төрийн албаны тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга Дашпүрэвийн Баярхүү нь эрүүл мэндийн шалтгаанаар ажлаас чөлөөлөгдөх хүсэлтээ гаргасан тул 2022 оны 12 дугаар сарын 14-өөс тасалбар болгон үүрэгт ажлаас чөлөөлсүгэй.

2. Ажил хүлээлцүүлэх комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга: Э.Мөнх-Эрдэнэ Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга

Гишүүд: С.Бат-Эрдэнэ Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн

Т.Хосбаяр Аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Архив, албан хэрэг хариуцсан мэргэжилтэн

Д.Уламбаяр Аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Захиргаа хуулийн асуудал хариуцсан мэргэжилтэн

С.Ариунжаргал Аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Нягтлан бодогч

3. Д.Баярхүүгийн ажлыг зохих хууль, журмын дагуу хүлээлцүүлэхийг Комиссын бүрэлдэхүүн (Э.Мөнх-Эрдэнэ)-д, холбогдох тооцоог хийж дуусгахыг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Нягтлан бодогч (С.Ариунжаргал)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Ц.ЧОГСОМЖАВ